



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 276,866.8 мянган төгрөг буюу 32.9 хувиар дутуу төвлөрүүлж, Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос нийт 217,390.4 мянган төгрөг буюу 80.3 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2016 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймгийн аудитын газар Тэргүүлэх аудитор Ш.Ичинхорлоо Аудитын менежер Б.Сарантуяа Аудитор Г.Наранбаяр Аудитор Л.Отгонпүрэв 2016 оны 06 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151 дугаарын утас, 7054-3179 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 217 тоот	Товчилсон үгийн тайлбар4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй5 БҮЛЭГ 1: Байгаль хамгаалах, нөхөн сэргээх талаар гаргасан аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт 91.0 хувь, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт 99.3 хувьтай байна. 1.1. 2010-2015 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар аймгийн ИТХ-ын 9 тогтоол гарсан бөгөөд аймгийн БОАЖГ-аас жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж ирсэн байна. 1.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, аймгийн ИТХ-ын тогтоолоор батласан арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 11 захирамж гарсан бөгөөд хэрэгжилт нь 99,3 хувьтай байна. БҮЛЭГ 2: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс орлого 276,866.8 мянган төгрөг буюу 32.9 хувиар тасарсан байна. 2.1 2015 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг ИТХ-аар батлуулахдаа 35,952.4 мянган төгрөгөөр дутуу төлөвлөж, батлуулсан байна. 2.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 276,866.8 мянган төгрөг буюу 32.9 хувиар дутуу төвлөрүүлсэн байна. БҮЛЭГ 3: Орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагатай уялдуулан зарим журам, зааврыг зайлшгүй шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. 3.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хувь хэмжээг баримтлаагүйгээс 82,123.3 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна. 3.2. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 208,504.3 мянган төгрөгийг ойжуулалттай холбоотой арга хэмжээнд зарцуулсан байна. 3.3 Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос нийт 217,390.4 мянган төгрөг буюу 80.3 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.
---	--

	3.4 Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу хуваарилсан боловч орлогыг зарцуулаагүй байна. 3.5 2015 онд 4 байгууллагын ашигласан 194,921.6 м³ буюу 17,309.0 мянган төгрөгийн усыг ус, рашааны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлсөн байна. БҮЛЭГ 4: Аймгийн ИТХ, Засаг дарга, МХГ-ын зүгээс байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын тайлан байхгүй байна. 4.2. Аймгийн БОАЖГ сумдын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаа нь байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сулруулсан байна. Дүгнэлт..... Зөвлөмж..... Холбогдох байгууллагын санал:..... Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал Саналд өгсөн тайлбар Хавсралтууд
--	---

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт: Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, аймаг, сумдын хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам батлаж биелэлтийг хангуулах үйл ажиллагаа нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцэж буй эсэхэд Нийцлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын хамарсан хүрээ: Аудитад аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, аймаг, сумдын ИТХ, Засаг дарга түүний харъяа байгууллага, Татварын хэлтэс, холбогдох аж ахуй нэгжүүдийг хамруулан тэдгээрийн ажлын тайлан, тайлагналтай холбоотой бусад холбогдох баримт материал, статистик мэдээ, судалгааны материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй: Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт, шалгалтын стандарт, Нийцлийн аудитын аудитын гарын авлага, АДБОУС 4000-4200, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, харьцуулан шинжлэх, түүвэрчлэн шалгах зэрэг сорил, горимуудыг хэрэгжүүлэн эрсдэлийг илрүүлж, үнэлэх зэрэг аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Үндсэн мэдээлэл:

Аймгийн БОАЖГ нь аймгийн нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалын хөгжүүлэх талаар явуулж байгаа төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага юм.

Аймгийн БОАЖГ-ын Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг дарга Д.Мөнх-Эрдэнэ, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ц.Цэрэнчимэд нар зурж захиран зарцуулж байна.

2015 онд аймгийн ИТХ-ын 05 дугаар тогтоолоор байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд нийт 279,639.0 мянган төгрөгийг баталсан байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хөрөнгө оруулалтын 5 ажилд 185,049.3 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр санхүүжилт 185,049.3 мянган төгрөгийг санхүүжүүлсэн, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд 71,321.3 мянга, 2014 оны хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэл санхүүжилтэд 14,200.0 мянга нийт 270,570.6 мянган төгрөгийг зарцуулж, БХНСАХ-ний зардлын зарцуулалт 96.8 хувьтай байна.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 10 дугаар тогтоолоор 2016 оны аймгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 222,750.0 мянган төгрөг баталсанаас эхний хагас жилийн байдлаар хуваарийн дагуу 133,500.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2016 оны эхний хагас жилд олгосон санхүүжилтээс 86,076.1 мянган төгрөгийг зарцуулж, 47,423.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

БХНСАХ-ний зардлаас 43,215.0 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд, 42,861.4 мянган төгрөгийг төсөл, арга хэмжээний зардалд тус тус зарцуулсан байна.

Аймаг сумдын ИТХ, Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргийг биелүүлсэн эсэх

Бүлэг 1

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх талаар гаргасан аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт 91.0 хувь, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт 99.3 хувьтай байна.

1.1. 2010-2015 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар аймгийн ИТХ-ын 9 тогтоол гарсан бөгөөд аймгийн БОАЖГ-аас жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж ирсэн байна.

Аймгийн ИТХ-аас 2010-2015 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаатай холбоотой 9 тогтоол гаргасан байна. Үүнээс 3 тогтоол нь 2015 онд гарсан бөгөөд өмнөх оны тогтоолуудаар батлагдсан үнэ тариф, төлбөрийн хэмжээ болон хөтөлбөр, журмын хэрэгжилтийг жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланд тусган хэрэгжүүлж ирсэн байна. Үүнд:

- Байгаль орчны талаар авах зарим арга хэмжээний тухай, 2010.11.16, №80, /Цөлжилттэй тэмцэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх аймгийн дэд хөтөлбөр баталсан/
- Хөтөлбөр батлах тухай, 2011.07.18, №56 /Ус дэд хөтөлбөр/
- Үнэлгээ тогтоох тухай, 2011.12.20, №97 /1м² талбайд ногоон байгууламж байгуулах ажлын болон 1 мод тарих ажлын зардал батлах/
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тогтоох тухай, 2012.07.31, №70 /Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр тогтоох/
- “Экологийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр” батлах тухай, 2013.11.27, №64
- “Байгаль орчны мастер төлөвлөгөө” батлах тухай, 2014.05.06, №18
- Хог хаягдал гаргасны төлбөр тогтоох тухай, 2014.01.16, №04 /Говьсүмбэр аймгийн хэмжээнд дагаж мөрдөгдөх иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын сарын хог хаягдал гаргасны төлбөр/
- Журам батлах тухай, 2015.02.09, А/07 /Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуй нэгж байгууллага урамшуулал олгох журам/
- Цагаан зээр агнах зөвшөөрөл олгох тухай, 2015.10.05, А/30

Аймгийн ИТХ-ын тогтоолоор байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2015 онд 279,639.9 мянга, 2016 онд 222,750.0 мянган төгрөгийг тус тус баталсан байна. Уг тогтоолоор аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтыг хамт баталсан байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор 2015 оны Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төсөв, Байгаль хамгаалах сан, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төсвийг тус тусад нь баталсан боловч 2015 оны 01 дүгээр сард Сангийн яамнаас ирүүлсэн Сангийн сайдын 4/1-416 дугаартай албан тоотын дагуу аймгийн Байгаль хамгаалах сангийн зарлага болон байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төсвийг БОАЖГ-ын үйл ажиллагааны зардлын төсөвтэй нэгтгэн тус газрын үйл ажиллагааны зардлын нэг зүйл анги болгон Засгийн газрын тусгай санг татан буулгах, нэгтгэх тухай ямар нэгэн тогтоол, шийдвэр гараагүй байхад зөвхөн СС-ын албан тоотоор нэгтгэсэн байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Тусгай санг хуулиар байгуулна”, 5.4-т “Тусгай сан дараахь төрөлтэй байна”, 5.4.2-т “Байгаль хамгаалах сан”, 12 дугаар зүйлийн 12.1.2-т “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуулийн 4.2 дахь хэсэгт заасан мөнгөн хөрөнгө” гэснийг тус тус зөрчсөн байна.

Сумдын ИТХ-аас сумдын 2015 оны Байгаль хамгаалах сангийн төсвийг батлаагүй бөгөөд Сүмбэр сумын байгаль хамгаалах санд ан агнуурын зөвшөөрлийн хураамж болон хайгуулын болон ашиглалтын лицензтэй компанийн нөхөн сэргээх зардлын барьцаа хөрөнгө нийт 24,852.9 мянга, Баянтал сумын Байгаль хамгаалах санд хайгуулын лицензтэй компанийн нөхөн сэргээх зардлын барьцаа хөрөнгийн орлого 1,800.0 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Уг төвлөрүүлсэн орлогыг Баянтал болон Сүмбэр сумдын ИТХ-ын хурал 2015 онд хуралдаж төсөвтөө тодотгол хийгээгүйгээс шалтгаалан зарцуулаагүй байна. Нөхөн сэргээх арга хэмжээний зардлын барьцаа хөрөнгийг тусгай дансанд байршуулах ёстой боловч байгаль хамгаалах сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу БОАЖГ-аас төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажилласан байна. 2015 онд ИТХ дэд хөтөлбөр 3, мастер төлөвлөгөө 1, төлбөр тогтоох болон зөвшөөрөл олгох тухай 4 тогтоол гарсан байна.

Үүнд: Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр болон цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан дэд хөтөлбөрийн дагуу арга хэмжээний төлөвлөгөө гарган 5 зорилтын хүрээнд 13 га ойн зурвас байгуулж, 6,9 га талбайд

нөхөн сэргээлт хийж, нийт 29,241 мод тарьсан ба мод тарьсан иргэдэд урамшуулал олгож, 14 худаг шинээр гаргасан байна.

Ус дэд хөтөлбөрийн хүрээнд уст цэгийн тоо бүртгэлийн ажлыг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаатай хамтран зохион байгуулсан ба аймгийн хэмжээнд 337 худаг, гол горхи 6, нуур тойром 8, булаг шанд 17, рашаан 1, хөв цөөрөм 2, баянбүрд 1 тоологдсон байна.

Орон нутгийн ААНБ-уудыг тоолууржуулах, Шивээговь сумын Хаялагын усыг ашиглаж аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд 30 га талбайд жимсний төгөл болон төмс, хүнсний ногооны усалгаатай газар тариалан эрхлэх, мөн аймгийн төвийн болон Шивээговь сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн дэвсгэр талбайг хамарсан хяналт-шинжилгээний 4 цооног тоноглож улсын сүлжээнд холбох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Экологийн боловсрол хөтөлбөрийн хүрээнд “Эх байгалиа хайрлаж – Эрүүл амьдарцгаая” эко аяллыг ерөнхий боловсролын сургуулиудын Эко бүлгүүдийн 40 сурагчийг хамруулсан эко аялал, ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн эко бүлгийн сурагчдыг хамруулан Хаялага, Хүрийн ногоо орчмоор аялан ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэх ажил зохион байгуулсан байна.

“Ногоон хөгжлийн төлөөлөгч” бэлтгэх сургалт зохион байгуулах, орон нутгийн телевизээр Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хаврын мод тариалтын үе эхэлж байгаатай холбоотой мэдээ мэдээлэл хүргэх, ЕБС-ын 5-р сургуулийн сурагчдад мандлын цэцэг үрслүүлэх арга технологийг зааж арчилж хамгаалах талаар зөвлөмж өгөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулах зорилгоор байгаль хамгаалах иргэдийн 3 нөхөрлөл шинээр байгуулсан байна. Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл байгуулагдсанаар хээрийн түймэр болон хулгайн ангийн гаралт өмнөх оноос буурсан байна. Мөн нутгийн иргэд өөрсдийн хүчээр 2 хөв цөөрөм байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор “Мод тарьж ургуулсан иргэн, ААНБ-д урамшуулал олгох журам”-ыг батлуулсан байна. Уг журмын дагуу ААНБ, иргэдийн тарьсан модонд хийсэн тооллогоор 2014 онд тарьсан 444 мод, 2015 онд тарьсан 1478 мод тоологдсон бөгөөд 2014 онд таригдсан 444 модонд 2,930.0 мянган төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэснээс 2,822.5 мянга, идэвхтэн байгаль хамгаалагчдад 600.0 мянга, нийт 3,422.5 мянган төгрөгийн урамшуулалыг БХНСАХЗ-аас олгосон байна.

1.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 11 захирамж гарсан бөгөөд хэрэгжилт нь 99,3 хувьтай байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зорилтын хүрээнд баталсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 11 захирамж гарсан ба аймгийн хэмжээнд уг захирамжуудийн хэрэгжилтийг хангах үүднээс байгаль орчинг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр доорх ажлуудыг зохион байгуулсан байна. Үүнд:

1. АИТХ-аас баталсан “Экологийн боловсрол дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2015 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/128 дугаар захирамжаар баталсан бөгөөд уг төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- “Ногоон хөгжлийн төлөөлөгч” бэлтгэх сургалтад аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллагуудын төлөөллийг оролцуулан батламж гардуулсан,
- “Эх байгалиа хайрлаж–Эрүүл амьдарцгаая” эко аялалд Ерөнхий боловсролын сургуулиудын Эко бүлгүүдийн 40 сурагчыг, “Хос мөнгөн хүрд” дугуйн холбоотой хамтарч 31 дугуйчин, 34 аялагчийг хамруулсан дугуйн болон явган аяллыг тус тус зохион байгуулсан.
- “Тохижилт сүмбэр” ОНӨААТҮГ-тай хамтарч 3 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт булшилсан,
- Орон нутгийн телевизээр Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зэрэг мэдээ мэдээлэл хүргэсэн,
- Ногоон оффис уралдаан зохион байгуулж ААНБ-уудын тарьсан мод, бутанд тооллого хийж идэвхи зүтгэлтэй оролцсон байгууллагуудыг шалгаруулж шалгарсан байгууллагуудад тарьц суулгац худалдан авах эрхийн бичгээр шагнаж урамшуулсан зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна.

БОАЖГ болон Төрийн бус хөндлөгийн байгууллагаас олон нийтийн дунд явуулсан судалгаагаар дээрх ажлуудыг зохион байгуулснаар олон нийтийн хандлага өөрчлөгдөж экологид ээлтэй зан үйлийн тоо нэмэгдэж байгаа гэсэн дүн гарчээ.

2. Аймгийн Засаг даргын 2015 оны А/113 дугаартай Бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд “Сая мод ургуулах хөдөлгөөн”-ийг зохион байгуулах тухай захирамжийн дагуу Ойн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ААНБ бүр өөрийн эзэмшлийн талбайн 10-аас доошгүй хувьд ногоон байгууламж бий болгох зорилго тавьж захиалгат бүтээгдэхүүн болгон төсвийн шууд захирагч нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгуулан хэрэгжилтийн хангуулан ажилласнаар аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 77 аж ахуйн нэгж, байгууллага нийт 4008 ширхэг навчит мод тарьсан байна.

3. Аймгийн Засаг даргын 2015 оны А/93, А/281 дугаартай “Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах болон эргүүл шалгалт хийх тухай” захирамжийн дагуу хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, болзошгүй түймэр гарсан үед унтраах ажилд мэргэжлийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр малчид, байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд 5 нөхөрлөл байгуулж анхан шатны багаж хэрэгслээр хангасан байна.

Аймгийн МХГ, БОАЖГ, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, сумдын Засаг дарга нартай хамтран 57 удаагийн эргүүл шалгалтаар 500 гаруй иргэнд, нээлттэй хаалганы өдөрлөгүүдээр нийт 2000 гаруй иргэнд Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг сургалчлах ажлууд хийгдсэн байна.

4. Засаг даргын 2015 оны А/144 дүгээр захирамжаар Усны аюулгүй байдлын зөвлөл байгуулагдаж ДЗОУБ-тай хамтарсан Усны аюулгүй байдлын сургалт, Ус хангамжийн удирдах газар, Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтарч “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан байна.

5. Мөн бэлчээрийн менежментийг сайжруулах зорилтын хүрээнд аймгийн ЗД-ын 2015 оны А/271 дугаартай захирамжаар комисс томилогдож мэргэжлийн байгууллагаар эрчимжсэн мал аж ахуйн бүсэд усны хайгуул хийлгэж, инженерийн хийцтэй худаг гаргуулсан байна.

6. Засаг даргын 2015 оны А/189 тоот “Хог хаягдлын нэр төрөл, үүсэлтийн тоо хэмжээ тогтоох тооллогын ажил явуулах тухай” захирамжийн дагуу хог хаягдлын нэр төрөл, үүсэлтийн тоо хэмжээг тогтоох ажлын хэсэг байгуулж, айл өрхөөс гарч буй хог хаягдлын нэр төрөл, тоо хэмжээ норматив, бүтцийг тодорхойлох зун, өвлийн тооллогын ажлыг зохион байгуулсан байна. Уг тооллогын дүнд хог хаягдлын хэмжээг бууруулах, түүнийг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй аргаар зайлуулах, хог хаягдлаас үүсч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах чиглэлээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх арга хэлбэрийг тогтоох, хог хаягдлын улсын бүртгэл хөтлөх суурь мэдээллийг бүрдүүлэх эх суурийг тавьсан байна.

7. Аймгийн Засаг даргын 2015 оны А/196 тоот “Цэвэр орчин сарын аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулах” захирамжийн дагуу айл өрх аж ахуй нэгж, байгууллагын хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх маршрутыг батлан мөрдөж, ил задгай хогийн цэгүүдийг устгаж, Чойрын Богд уул, Цоорхой рашаан, Хаялга нуур зэрэг гол горхи, булаг шандны эх цэвэрлэж, хог тээврийн автомашин болон холбогдох байгууллагуудтай нь хамтран ариутгал хийж хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажилласан ба аймгийн хэмжээнд 2500 гаруй иргэн, албан хаагч, 50 аж ахуйн нэгж байгууллага хамрагдаж, 60 тн хог хаягдал цэвэрлэсэн байна.

8. Аймгийн Засаг даргын 2015 оны 272 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2015 онд Соёл, спорт амралтын хүрээлэнд модлог ургамлын цэцэрлэгт хүрээлэнгийн мод, ойн зурвас байгуулах 5 га талбайд тариалсан нийт 17,744 модыг хүлээж авсан байна.

Сүмбэр, Шивээговь сумдын Засаг даргын захирамжийн дагуу “хүн амын ундны ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоох” ажил зохион байгуулж, төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд хориглолтын, 500 метрээс доошгүй зайд хязгаарлалтын, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд хориглолтын, 200 метрээс доошгүй зайд хязгаарлалтыг бүсийг тус тус тогтоож, иргэдийг эрүүл ахуйн стандартад нийцсэн усаар хангах нөхцлийг сайжруулсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх

Бүлэг 2

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс орлого 276,866.8 мянган төгрөг буюу 32.9 хувиар тасарсан байна.

2.1 2015 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг ИТХ-аар батлуулахдаа 35,952.4 мянган төгрөгөөр дутуу төлөвлөж, батлуулсан байна.

Аймгийн Татварын хэлтэс Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн, бодитой төлөвлөж, батлуулаагүй байна. Уг орлогыг төлөвлөж, батлуулахдаа мэргэжлийн байгууллага болох БОАЖГ-аас санал аваагүй, орлого төвлөрүүлэх байгууллагуудын судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөөгүй зэргээс шалтгаалан орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөж батлуулсан байна. Энэ нь тухайн ажил хариуцсан байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо муу байгааг харуулж байна.

Тухайлбал: Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 426 дугаар тушаалаар тус аймагт 2 угалз агнах, ахуйн зориулалтаар 50 цагаан зээр агнах зөвшөөрлийг тус тус олгосон байтал 2015 оны Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө ан амьтны нөөц ашигласны төлбөрийн дээрх орлогыг төлөвлөгөөнд тусгалгүй орхигдуулан, зөвхөн ус рашаан ашигласны төлбөрийг тусган батлуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 06 дугаар тогтоолоор 2015 онд төвлөрүүлэх Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 790,000.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд тайлант онд 1 удаа төсвийн тодотгол хийж 51,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн орлогыг 841,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Мөн ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөгөөнд тусгалгүй 35,952.4 мянган төгрөгийг орлогыг орхигдуулсан байна.

Энэ нь холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу байгаагаас шалтгаалан зөвшөөрөлтөй ан агнуурын нөөц ашигласны төлбөрийг байгалийн нөөц ашигласны орлогын төлөвлөгөөнд тусган тодотгож батлуулаагүй байна. Мөн 2015 онд байгалийн нөөц ашигласны орлогын төлөвлөгөөг 32.9 хувиар тасалсан байгаа нь орвол зохих орлогыг бүрэн дайчилж төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Иймд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө үнэн зөв тооцоо судалгаанд үндэслэн өмнөх жилийн татварын авлагын тооцоо, тайлант онд байгалийн нөөц ашиглалтын талаар байгуулсан гэрээ, хэлцэл, түүний төлбөр, ус, рашаан ашиглаж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын судалгаанд үндэслэн орлогыг бодитой төлөвлөж, батлуулж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

2.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 276,866.8 мянган төгрөг буюу 32.9 хувиар дутуу төвлөрүүлсэн байна.

Байгалийн нөөцийн ашигласны төлбөрийн орлого нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т зааснаар дараах орлогуудаас бүрдэж байна. Үүнд:

1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого
2. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого
3. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого
4. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого
5. Газрын нөөцийн төлбөрийн орлого

Говьсүмбэр аймгийн хувьд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого зөвхөн ус, рашааны нөөц ашигласны төлбөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогуудаас бүрдэж байна.

2015 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 841,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 564,333.2 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 32,9 хувиар тасалсан байна.

2015 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

				/мян.төг/
Орлого		Төлөвлөгөө	Гүйцэтэл	Зөрүү
Байгалийн нөөц ашигласны төлбөрын орлого		841,000.0	564,333.2	276,866.8
1	Ус, рашааны ашигласны төлбөр	841,000.0	528,380.8	312,619.2
2	Угалз агнасны төлбөр / сүмбэр сумын орон нутгийн орлого /		24,852.9	-24,852.9
3	Угалз агнасны хураамж / аймгийн татварын орлого/		10,899.5	-10,899.5
4	Цагаан зээр агнасан зөвшөөрөл /аймгийн татварын орлого 100.0, сүмбэр сумын орон нутгийн орлого 100.0/		200.0	-200.0

Дээрх хүснэгтээс харахад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 276,866.8 мянган төгрөгөөр тасарсан байна.

Үүнээс **Ус рашаан ашигласны төлбөрийн орлогын** төлөвлөгөө 312,619.2 мянган төгрөгөөр тасарсан нь “Шивээ-Овоо” ХК Ус рашааны ашигласны төлбөрийг дутуу төвлөрүүлсэнээс шалтгаалсан байна.

Энэ нь жил бүр мэргэжлийн байгууллагаас усны дүгнэлт гаргаж, ус, рашаан ашигласны төлбөрийн хэмжээг тогтоож гэрээнд тусгаж өгдөг боловч тус аймаг дахь Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа нь “Шивээ-Овоо” ХК-тай ус, рашаан ашиглах гэрээг 2015 оны 1 дүгээр улиралд байгуулалгүй 3 дугаар улиралд байгуулж хугацаа хожимдуулснаас шалтгаалсан байна.

Мөн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан боломжит орлогуудыг төлөвлөхгүй байна. Тухайлбал: Ан, амьтаны нөөц ашигласны орлогыг төлөвлөөгүй боловч гүйцэтгэлээр 35,952.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь төлөвлөсөн нэр төрлийн орлогын төлөвлөгөөны тасалдлыг төлөвлөөгүй орлогоор нөхөж, хаасан харагдаж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан эсэх

Бүлэг 3

Орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагатай уялдуулан зарим журам, зааврыг зайлшгүй шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

3.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хувь хэмжээг баримтлаагүйгээс 82,123.3 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

2015 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 790,000.0 мянган төгрөгөөр батлагдсанаас 564,333.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно: ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг зарцуулна” гэж заасан байна.

Гэтэл дээрх хуулийн дагуу 2015 онд аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 790,000.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөнөөс нь тооцвол 35 хувь буюу 276,500.0 мянган төгрөгийг БХНСАХ-ний зардалд хуваарилан, зарцуулах байтал аймгийн ИТХ-ын 2014 оны 03 дугаар тогтоолоор 332,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна. Харин тайлант онд хийсэн төсвийн тодотголоор уг зардлыг 52,360.1 мянган төгрөгөөр бууруулж, 279,639.9 мянган төгрөгөөр баталж, 3,139.9 мянган төгрөгийг илүү тооцож, хуваарилсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлээс нь тооцвол 2015 онд төвлөрүүлсэн 564,333.2 мянган төгрөгийн орлогын 35 хувь буюу 197,516.6 мянган

төгрөгийг БХНСАХ-ний зардалд олгохоор байна. Гэтэл 2015 онд БХНСАХ-ний зардалд 279,639.9 мянган төгрөгийг олгохоор тооцож, батлуулан санхүүжилтийг 82,123.3 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Үүнээс харахад Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 2-ын аль алиныг нь хуулийн дагуу хуваарилалтын суурь үзүүлэлт болгон тооцоололгүй хийсвэрээр хуваарилалт хийж баталсан нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “..... ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг зарцуулна” гэснийг зөрчсөн байна.

Иймд БХНСАХ-ний зардлыг төлөвлөж, батлахдаа Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хувь хэмжээг баримтлан төлөвлөж байх, арга хэмжээний зардлыг орлогын гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.2. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 208,504.3 мянган төгрөгийг ойжуулалттай холбоотой арга хэмжээнд зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.2.4-т “аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, ойн ангитай зөвшилцөн аймаг, сум, нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнээс олсон орлогыг ойн нөөц ашигласны төлбөрт зарцуулах” гэсний дагуу тус аймагт уг орлогыг бүрдүүлэх боломжгүй юм.

Говьсүмбэр аймгийн байгаль экологийн онцлогоос шалтгаалан Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрдүүлэх боломжгүй боловч орон нутагт Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, нутгийн ард иргэдийн эрүүл, тав тухтай орчинг бүрдүүлэх, байгаль экологийн шаардлагыг хангах, цөлжилттэй тэмцэх зэргээс шалтгаалан зайлшгүй ойжуулалттай холбоотой арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх шаардлага гардаг.

Мөн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, БОНХАЖЯ-ны сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээ, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахын тулд дараах аймаг орон нутагт дараах дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр,
- Цөлжилттэй тэмцэх ногоон байгууламжийг нэмэгдүүлэх дэд хөтөлбөрүүд

Иймд 2015 онд дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн БОАЖГ-ын БХНСАХ-ний зардалд тусган ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоор санхүүжүүлж, ойжуулалтын арга хэмжээнд нийт 208,504.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Ойжуулалтын арга хэмжээний зарцуулалтыг нэр төрлөөр нь харуулбал:

/мян.төг/

Утга	2015 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү

Соёл, амралтын хүрээлэнгийн орчны тохижилт	101,695.5	101,000.0	695.5
Соёл, амралтын хүрээлэнд модлог ургамлын цэцэрлэг байгуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	27,301.9	26,800.0	501.9
МУ-ын ЗГ-ын “Ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд ойн зурвас байгуулах	6,000.0	5,797.6	202.4
Ойн ангийн ажиллагсдын цалин, ндш, томилолтын зардалд	40,904.7	40,896.9	7.8
Ойн ангийн усжилтын системийн моторыг ажиллуулах цахилгааны зардал болон мод услах усны зардалд	9,146.8	7,688.8	1,458.0
Ойн ангийн шаардлагатай тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцасны зардалд	5,539.4	5,533.9	5.5
Мод тарьсан иргэн, аж ахуйн нэгжид урамшуулал	5,000.0	3,422.5	1,577.5
Аж ахуйн нэгж, байгууллагад ногоон байгууламж бий болгох, мод бут тарих, хөрс сайжруулах	3,483.0	3,164.6	318.4
Соёл амралтын хүрээлэнд мод тарих, услах, арчлах ажил	14,200.0	14,200.0	0.0
Нийт дүн	213,271.3	208,504.3	4,767.0

Хүснэгтээс харахад 2015 онд ойжуулалтын арга хэмжээний зардалд 213,271.3 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 208,504.3 мянган төгрөгийг зарцуулж, арга хэмжээний төлөвгөөний биелэлт 74.6 хувьтай байна.

Аймгийн БОАЖГ нь 2015 онд байгалийн нөөц ашигласны төлбөрөөс зориулалт бусаар нийт 54,119.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- Ойн ангийн ажиллагсдын цалин, ндш, томилолтийн зардалд 40,896.9 мянга,
- тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцасанд 5,533.9 мянга,
- ойн ангийн услалтын системийн моторыг ажиллуулах, цахилгааны болон мод услах ус, шатахууны зардалд 7,688.8 мянга

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.3.1-т “аймаг болон тухайн сумын ой зохион байгуулалт хийх, ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх арга хэмжээ авах, нөхөрлөл, ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг дэмжих” гэснийг зөрчсөн байна.

Мөн сургалтын зардалд 373.6 мянга, хөрс, шороо бэлтгэх шатахууны зардалд 1,591.0 мянга, “Ногоон харш” ХХК-ын модны нүх ухах зардалд 1,200.0 нийт 3,164.6 мянган төгрөгийг зарцуулахдаа нэхэмжлэх, гэрээ хоёрын тоон дүн зөрүүтэй, хүлээж авсан ажлын тайланд хэдэн нүх ухсан нь тодорхойгүй, хөрс, шороо бэлтгэх ажлыг дүгнэсэн гэрээ хийгдээгүй, жолоочийн тооцооны хуудас гарын үсэг байхгүй зэрэг зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогыг хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын зарим зүйл заалт нь ой, ургамлын нөөцгүй, орлого олох боломжгүй манай аймгийн хувьд хэрэгжүүлэн ажиллахад хүндрэлтэй байдаг ба усны асуудлаас бусад асуудлыг шийдвэрлэх, санхүүжүүлэх боломжгүйгээс холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөж байна.

Иймд ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогыг хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг орон нутгийн байгаль экологийн онцлог, хэрэгцээ шаардлагатай уялдуулан шинэчлэн боловсруулах шаардлагатай байгаа тул холбогдох дээд шатны байгууллагад уламжлуулахаар шийдвэрлэв.

3.3 Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос нийт 217,390.4 мянган төгрөг буюу 80.3 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2015 онд аймгийн ИТХ-аар батлагдсан Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хөрөнгө оруулалтын 5 ажилд 185,049.3 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 185,049.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд 71,321.3 мянга, 2014 оны хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэл санхүүжилтэд 14,200.0 мянга нийт 270,570.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтыг ажлын гүйцэтгэгчийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 2 ажлыг шууд гэрээгээр, 2 ажлыг харьцуулалтын аргаар, 1 ажлыг нээлттэй тендер зарлаж, сонгон шалгаруулсан байна. Үүнд:

1. “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын төсвөөс 10,000.0 мянга, БХНСАХ-ний зардлаас 5,700.0 мянган төгрөгийг зарцуулан улсын чанартай автозамын дагуу 5 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулан 3,741 мод бут тарьж, ургалт 80 хувьтай, өмнөх онтой харьцуулахад модны амьдралт 10 хувиар буурсан байна.
2. “Цөлжилттэй тэмцэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн Соёл, спорт амралтын хүрээлэнд 4 га талбайд 4,714 мод бутыг тарьж, 26,800.0 мянган төгрөг, 3 га талбайд ойн зурвас байгуулахад 5,797.6 мянган төгрөг, 8 га талбайн усалгааны шугам, 50 тн усны нөөц сав байршуулахад 29,951.7 мянган төгрөг нийт 62,549.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.
3. Бэлчээрийн менежментийг сайжруулах зорилгоор усны хайгуул хийж, инженерийн хийцтэй худаг гаргахад 22,000.0 мянган төгрөг, Соёл амралтын хүрээлэнг тохижуулах, орчныг сайжруулахад 101,000.0 мянган төгрөг нийт 123,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2015 онд Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос нийт 279,639.9 мянган төгрөгийг БХНСАХ-ний зардалд зарцуулахаар баталсанаас гүйцэтгэлээр 270,570.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүний 53,180.1 мянган төгрөг буюу 8.5 хувийг зориулалтын дагуу, 217,390.4 мянган төгрөг буюу 80.3 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

Зориулалтын дагуу зарцуулсан зардлыг авч үзвэл:

1. Усны болон хог хаягдлын нэгдсэн тоо бүртгэлийг сайжруулахад 1,728.5 мянга,
2. Бэлчээрийн менежментийг сайжруулах зорилгоор усны хайгуул хийж, инженерийн хийцтэй худаг гаргахад 21,500.0 мянга,

3. Соёл, амралтын хүрээлэнд услалтын систем, дагалдах тоног төхөөрөмж, ус нөөцлөх сав суурилуулах зардалд 29,951.6 мянга,

Зориулалт бусаар зарцуулсан зардлыг авч үзвэл:

1. Ойжуулалтын арга хэмжээний зардалд 208,504.3 мянга,
2. Ургамал, ан амьтныг хамгаалах арга хэмжээний зардалд 8,886.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь 3Г-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогыг хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг зөрчсөн байна.

3.4 Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу хуваарилсан боловч орлогыг зарцуулаагүй байна.

2015 онд БОНХАЖЯ-аас баталсан “Сүмбэр” агнуурын бүс нутгийн орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн БОНХС-ын 2014 оны А/426 дугаар тушаалын дагуу Сүмбэр суманд 2 угалзыг тусгай зориулалтаар агнахаар төлөвлөсөн боловч ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогыг байгалийн нөөц ашигласны орлогын төлөвлөгөөнд тусгаж батлуулаагүй, мөн ан агнуурын нөөц ашигласны орлогыг хуульд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь 3Г-ын 2013 оны 93 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.6-д “Агнуурын бүс нутагт тусгай зөвшөөрлөөр агнаж, барьсан ан амьтны төлбөрийн 50-иас доошгүй хувийг зөвхөн тухайн агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулна” гэснийг зөрчиж байна.

2015 онд Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого нийт 35,952.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэнээс Сүмбэр сумын Байгаль хамгаалах сангийн дансанд 24,952.9 мянга, аймгийн татварын орлогын дансанд 10,999.5 мянган төгрөг тус тус төвлөрсөн байна. Тайлант онд Сүмбэр сумын ИТХ Байгаль хамгаалах сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг тодотгож, батлаагүйгээс Байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн орлого зарцуулагдаагүй байна.

Аудитын явцад угалз агнах тухай байгуулсан гэрээ болон гэрээний биелэлт тооцсон баримт материалыг Сүмбэр сумын Байгаль хамгаалагч нь солигдсон шалтгаанаар ирүүлээгүй тул гэрээний дагуу төлбөр орсон эсэхийг тулган баталгаажуулах боломжгүй байлаа.

Иймд ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын ажлыг хүлээлцүүлэхдээ ажил хүлээлцүүлэх комисс томилж, баримт материалыг бүрэн хүлээлцэж, төрийн байгууллагын баримт материалын бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.5 2015 онд 4 байгууллагын ашигласан 194,921.6 м³ буюу 17,309.0 мянган төгрөгийн усыг ус, рашааны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлсөн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу дараах орлогуудыг усны төлбөрөөс чөлөөлж, хөнгөлөхөөр заасан байна. Үүнд:

1. Хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах
2. Түймэр унтраах болон байгалийн бусад гамшигтай тэмцэх
3. Гадаргууны усыг газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах

Дээрх хуулийн заалтын дагуу 2015 онд 4 аж ахуйн нэгж, байгууллагын ашигласан нийт 194,921.6 м³ буюу 17,309.0 мянган төгрөгийн усыг ус, рашааны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлсөн байна.

Усны нөөц ашигласны төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан байгууллагуудын жагсаалтыг хүснэгтээр харуулбал:

№	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Унд, ахуй	Ногоон байгууламж, усалгаа, биологийн нөхөн сэргээлт	Төлбөрөөс чөлөөлсөн усны хэмжээ, м3/жил	1м³ усны нөөц ашигласны төлбөр	Нийт дүн
1	Шивээ-Овоо ХК	Нүүрс олборлож дотоодын зах зээлд борлуулах	25476.7		25476.7	88.8	2,262.3
2	УС-ДУ ОНӨҮГ	Цэвэр ус олборлон түгээх. Дулаан үйлдвэрлэн түгээх	88552	500	89052	88.8	7,907.8
3	Илчлэг Шивээ ОНӨҮГ	Цэвэр ус олборлон түгээх. Дулаан үйлдвэрлэн түгээх.	38103		38103	88.8	3,383.5
4	УБТЗ-ЭХУХ-2 дугаар анги	Цэвэр ус олборлон түгээх. Дулаан үйлдвэрлэн түгээх.	42289.9		42289.9	88.8	3,755.3
Нийт дүн			194421.6	500	194921.6	88.8	17,308.9

Дээрх хүснэгтээс харахад нийт хөнгөлөлт, чөлөөлөлтийн 99.7 хувь буюу 194421.6 м³ усыг унд, ахуйн хэрэглээнд, 0.3 хувь буюу 500 м³ усыг биологийн нөхөн сэргээлтэд тус тус ашигласан байна.

Ус рашааны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөх байгууллагуудын ашигласан болон чөлөөлөгдөх усны хэмжээг Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дахь заалтыг үндэслэн БОНХАЖЯ-аас ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулан, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанаас олгосон зөвшөөрөл, ус ашигладаг байгууллагуудтай хийсэн гэрээг үндэслэн тогтоосон байна.

Бүлэг 4

Аймгийн ИТХ, Засаг даргын зүгээс байгаль орчныг
хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт
шалгалтын тайлан байхгүй байна.

4.2. Аймгийн БОАЖГ сумдын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаа нь байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сулруулсан байна.

Аймгийн БОАЖГ-ын даргын 2014 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан дотоод хяналтын нэгж томилогдон хяналт шалгалт хийсэн гэх боловч 2015 онд хийгдсэн хяналт шалгалтын тайлан байхгүй байна.

Аймгийн МХГ-т орон тооны байгаль орчны байцаагчгүй, өөр байцаагч хавсран гүйцэтгэж байгаа бөгөөд эрсдэлд суурилсан шалгалт хийдэг болсноос шалтгаалан 2015 онд байгаль орчны хуулийн хэрэгжилттэй холбоотой төлөвлөгөөт хяналт, шалгалт хийгдээгүй, хяналтын талаар тайлан мэдээ байхгүй байна.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу “Байгаль хамгаалах намрын аян”-ы хүрээнд аймгийн БОАЖГ-аас МХГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Цагдаагийн хэлтэс, Татварын хэлтэстэй хамтран гаргасан удирдамжийн дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагааны талаар судалгаа авч цэгцлэх зорилгоор сумдад чиглэл хүргүүлж эвдэрсэн газрын судалгааг гаргах, түгээмэл тархацтай ашигт малтмал хууль бусаар олборлодог газруудад хэмжилт хийх зэргээр олборлон худалдаалж байж болзошгүй хувь хүн, компаниудын үйл ажиллагаанд 2 удаагийн хяналт шалгалтаар 15 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан байна.

Уг шалгалтаар “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль”, “Газрын хэвлийн тухай хууль”, холбогдох дүрэм, журмын биелэлт, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үүднээс хууль бусаар хүнд машин механизм ашиглан их хэмжээгээр түгээмэл тархацтай ашигт малтмалыг олборлож хувь хүн болон ААНБ-уудад зарж борлуулж байсан этгээдүүдийг илрүүлж, цаашид уг этгээдүүдээр эвдэрсэн газруудыг нөхөн сэргээлгэх, газарт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр Цагдаагийн хэлтэст шилжүүлсэн байна.

Аймгийн БОАЖГ-аас Монголын байгаль орчны ГСА дахь зөвлөл, байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлүүдтэй хамтарч зэрлэг амьтдын нүүдлийг тандан судлах, эргүүл шалгалтын ажлыг тогтмолжуулж нийт 20 гаруй хамтарсан шалгалт хийгдсэн зэрэг холбогдох байгууллага, иргэд, нөхөрлөлүүдтэй хамтран хяналт шалгалт зохион байгуулж ажилласан боловч тухайн хяналт шалгалтын талаарх бичмэл тайлан байхгүй, зөвхөн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх илтгэх хуудсаар тайлагнасан байна.

Сумдын ЗДТГ-ын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг тогтвор сууршилтай ажиллуулаагүйгээс олон удаа солигдсон, улсын байцаагчийн эрхгүй болон мэргэжлийн бус хүн ажиллуулсан зэргээс шалтгаалан аудитын явцад сумдын байгаль орчны үйл ажиллагаатай холбоотой баримт материалуудыг ирүүлээгүй болно. Мөн аймгийн БОАЖГ нь сумдын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй ажлын уялдаа холбоогүй, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаагүй, сумдын ЗДТГ нь мэргэжилтнүүдийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнээгүй байна.

Иймд аймгийн БОАЖГ нь сумдын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй ажлын уялдаа холбоог сайжруулж, мэргэжил арга зүйгээр хангах, сумдын ЗДТГ байгаль орчны асуудлыг хариуцсан ажилтныг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, тогтвор сууршилтай ажиллуулах, ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажил хүлээлцүүлэх комисс томилж, баримт материалыг бүрэн хүлээлцэж, төрийн байгууллагын баримт материалын бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах талаар холбогдох албан тушаалтанд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Мөн аймгийн ИТХ, Засаг даргын зүгээс байгаль орчныг хамгаалах хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан тухай тайлан байхгүй байна.

Энэ нь аймаг, сумдын ИТХ болон Засаг дарга нар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Иймд аймаг, сумдын ИТХ болон Засаг дарга нар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар нийт 615,332.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Уг алдаа, зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байх талаар холбогдох зөвлөмжүүдийг өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

Зорилт:1

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай аймгийн ИТХ-ын 9 тогтоол, уг тогтоолын хэрэгжилтийг хангах, байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 11 захирамж гарсан ба ИТХ-ын тогтоолын хэрэгжилт 91.0 хувь, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт 99.3 хувьтай байна.

Зорилт:2

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс орлогыг нийт 276,866.8 мянган төгрөг буюу 32.9 хувиар дутуу биелүүлсэн, 2015 оны Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогод орон нутагт агнах зөвшөөрөл олгогдсон ан амьтны нөөц ашигласны төлбөрийг тусгалгүй орхигдуулан, зөвхөн ус рашаан ашигласны төлбөрөөр орлого бүрдүүлэхээр тусган, орлогыг дутуу тооцож төлөвлөж, батлуулсан байна.

Зорилт:3

2015 онд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн БОАЖГ-ын БХНСАХ-ний зардалд тусган ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоор санхүүжүүлж, ойжуулалтын арга хэмжээнд нийт 208,504.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Говьсүмбэр аймгийн байгаль экологийн онцлогоос шалтгаалан Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрдүүлэх боломжгүй боловч орон нутагт Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, нутгийн ард иргэдийн эрүүл, тав тухтай орчинг бүрдүүлэх, байгаль экологийн шаардлагыг хангах, цөлжилттэй тэмцэх зэргээс шалтгаалан зайлшгүй ойжуулалттай холбоотой арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх шаардлагын дагуу БХНСАХ-ний зардлыг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой байна.

Зорилт:4

Аймаг, сумдын ИТХ болон Засаг дарга нар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан хуулиар хүлээсэн эрхээ хэрэгжүүлж хангалтгүй хэрэгжүүлсэн, мөн аймгийн БОАЖГ нь сумдын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй ажлын уялдаа холбоогүй, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаагүй, сумдын ЗДТГ нь мэргэжилтнүүдийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнээгүй зэргээс шалтгаалан Байгаль орчныг хамгаалах тухай хуулиудын хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга Г.Батзам-д:

1. Аймгийн ИТХ-аар БХНСАХ-ний зардлыг батлахдаа Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хувь хэмжээг баримтлан төлөвлөсөн эсэхийг хянадаг байх, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлтэй уялдуулан баталж байх,
2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны зардлыг зориулалтын дагуу батлаж, хэрэгжилт, зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах,
3. Аймаг, сумдын ИТХ болон Засаг дарга нар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаа эсэхэд тавих хяналтыг эрчимжүүлэх,

Сумдын ЗДТГ-ын дарга нарт:

1. Ажлаас чөлөөлж буй ажилтнуудын ажлыг хүлээлцүүлэхдээ ажил хүлээлцүүлэх комисс томилж, баримт материалыг бүрэн хүлээлцүүлж, төрийн байгууллагын баримт материалын бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах,
2. Сумдын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн ажлын чиг үүргийг тодорхой болгох,
3. БО-ны мэргэжилтний ажлын тайланг нь хагас, бүтэн жилээр гаргуулан, ажлын үр дүнгийн гэрээний биелэлтийг тооцож ажиллах,
4. Байгаль орчны хуулийн хэрэгжилтийг хангах талаар орон нутагт ажил зохион байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах,

Аймгийн Татварын хэлтсийн дарга П.Энхоюун-д:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг үнэн зөв тооцоо судалгаанд үндэслэн өмнөх жилийн татварын авлагын тооцоо, тайлант онд байгалийн нөөц ашиглалтын талаар байгуулсан гэрээ, хэлцэл, түүний төлбөр, ус, рашаан ашиглаж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын судалгаанд үндэслэн бодитой төлөвлөж, батлуулж байх,

Аймгийн БОАЖГ-ын дарга Д.Мөнхэрдэнэ-д:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө тайлант онд байгалийн нөөц ашиглалтын талаар байгуулсан гэрээ, хэлцэл, түүний төлбөр, ус, рашаан ашиглаж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын судалгааг үндэслэсэн бодит саналыг хүргүүлэн батлуулж байх,

2. Аймгийн Ойн анги нь аж ахуйн тооцоотой байгууллага тул ажилтнуудын цалин, НДШ, хөдөлмөр хамгаалалын хувцас, тоног төхөөрөмж зэрэг урсгал үйл ажиллагааны зардлыг төсвөөс буюу БХНСАХ-ний зардлаас санхүүжүүлэхгүй байх,
3. Төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй арга хэмжээ, гүйцэтгэсэн ажлын баримт материалыг бүрдлийг хангаж ажиллах,
4. Сумдын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулан, мэргэжил арга зүйгээр хангаж, байгаль орчныг хамгаалах ажлын тайлан мэдээг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргадаг байх.

ҮАГ-ЫН НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:

1. ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогыг хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг орон нутгийн байгаль экологийн онцлог, хэрэгцээ шаардлагатай уялдуулан шинэчлэн боловсруулах, орон нутгийн онцлогийг харгалзан орлогын бүрдүүлэлт, зарцуулалтыг тогтоох шаардлагатай байгаа тул УИХ болон холбогдох мэргэжлийн байгууллагад уламжлах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ

Аймгийн БОАЖГ-аас ирүүлсэн тайлбар:

ГОВЬСҮМБЭР АЙМАГ БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР 42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Чойр, Утас: 7054 3063	АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.ИЧИНХОРЛОО ТАНАА
2016.10.14 № 204 танай 2016.10.10-ны № 226 -Т	
Нийцлийн аудитын тайланд санал хүргүүлэх тухай	
Байгаль хамгаалах тухай хууль болон Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцаад дараах санал хүргүүлж байна. 1. Тайланд хийгдсэн зарим дүгнэлтийг залруулах талаар: Тайлангийн 3 дугаар бүлгийн 1-д Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хувь хэмжээг баримтлаагүйгээс 82 123.3 мянган төгрөгийг 35 хувиас илүү тооцож олгосон гэж дүгнэжээ. Үүний 55 412.6 мянган төгрөг нь 2014 оны хэмнэгдсэн төсвийг дараа онд нэмж тодотгуулсан дүн болно. Түүнчлэн дээрх хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд зарцуулах зардлын зөвхөн "доод хязгаар"-ыг л тогтоож өгсөн тул зардлын хэмжээ заавал 35 хувьтай тэнцүү байхаар хуульчлаагүй бөгөөд дээш илүү байх боломжтой гэдгийг харгалзан үзнэ үү. ИТХ-ын 2015 оны төсвийн тодотгол хийсэн 2015 оны 12 дугаар сарын 04 ны өдрийн 06 дугаар тогтоолын 2.1.1.5-д Үйлдвэр үйлчилгээний зориулалтаар ашигласан усны орлогын төлөвлөгөөг 841 000.0 мянган төгрөг болгон шинэчлэн тогтоосон байх боловч Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хэмжээнд өөрчлөлт оруулаагүй бөгөөд өмнөх буюу 2015 оны 02 сарын 24 ны өдрийн 05 дугаар тогтоолын дүнгээр хэвээр 279 639.9 мян төгрөгөөр батлагдсан тул манай байгууллагад холбогдох өөрчлөлт ороогүй, шинэ хавсралт гараагүй тул шинээр тодотгол хийсэн тогтоол ИТХ-аас манай байгууллагад ирээгүй учир аудитын шалгалтад хамрагдсан баримтад ороогүй байсан байна. / ИТХ-ын 2015 оны 05, 06 дугаар тогтоолуудыг хавсаргае./ Харин нийцлийн аудитын явцад аудитор татварын хэлтсээс дээрх шинэчлэгдсэн тогтоолын 841 000.0 мянган төгрөгийн дүнг татварын хэлтсээс шууд мэдээ хэлбэрээр нь авч шинээр гарсан тогтоолын усны орлогын дүнг 2015 оны хуучин 05 дугаар тогтоолын 790 000.0 мянга ба шинээр гарсан 06 дугаар тогтоолын 841 000.0 мянган төгрөгийг харьцуулан 51 000.0 мянган төгрөгийн зөрүүтэй татварын төлөвлөгөөг баталсан байна гэж буруу ойлгосон байх тул үүнийг залруулна уу. Мөн орлогын дутуу төвлөрүүлэлттэй холбоотой татварын хэлтсийн тайлбарыг хавсаргав. / Татварын хэлтсийн 2016.№ 02/538 албан бичгийг хавсаргае./ Тайлангийн 3 дугаар бүлгийн 3.3-т дурьдсан ус ашигласны төлбөрийн орлогоос 217390.4 мянган төгрөг буюу 80 хувь зориулалт бусаар зарцуулсан гэж дүгнэжээ. Манай аймгийн хувьд байгалийн нөөц ашигласны төлбөр нь усны нөөц	

0000267

ашигласны төлбөрөөс бүрэн бүрддэг учир орлогыг бүхэлд нь усны чиглэлийн ажилд зарцуулан байгаль хамгаалах бусад ажлаа орхигдуулах боломжгүй тул уг харилцааг зохицуулж байгаа ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолд заасны дагуу бусад байгаль хамгаалах чиглэлийн ажилд журмын дагуу зориулж ажилласан болох нь ИТХ-ын тогтоолд зүйл бүрээрээ тодорхой туссан байгаа тул "зориулалт бусаар зарцуулсан" гэсэн үг хэллэг нь огт өөр салбарын ажилд зориулсан мэт ташаа ойлголтыг нийгэмд төрүүлж байгааг анхаарч үзэн нэр томъёоны сонголтыг эргэн харж зөвхөн орлогын эх үүсвэр бүрдэлт тал дээр зохицохгүй заалтыг гарган ирж нийцлийн аудитын зорилгын хүрээнд бодит байдалтай нийцэхгүй байгаа уг тогтоолыг засварлуулах ажилд дэмжлэг үзүүлнэ үү.

Шалгалтын танилцуулгын 4 дүгээр бүлэгт Байгаль орчны хууль тогтоомжийн хяналтын талаар хангалтгүй байна хэмээн дүгнэлт өгчээ. Байгаль хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу "Байгаль орчны хяналтын чиг үүргийг Мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүнэ" гэж заасан бөгөөд аудитын явцад Мэргэжлийн хяналтын чиглэлээр хийгдсэн ажлыг тухайн байгууллагаас нь лавлаж хамруулалгүй зөвхөн манай байгууллагын дотоод хяналт, байгаль хамгаалагчдын тайлангийн хүрээнд хязгаарлан дүгнэлт хийсэн нь учир дутагдалтай байна. Иймд мэргэжлийн хяналтын байгаль орчны хяналтын байцаагчийн тайланг тухайн байгууллагаас нь татан авч хүргүүлж байна. Хяналтын үйл ажиллагаа сайжирсанаар байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, захиргааны зөрчлийн илэрүүлэлт нэмэгдэж сүүлийн 2 жилд хууль бус агнуурын хэрэгт 2 иргэн эрүүгийн хариуцлага 10 гаруй иргэн захиргааны хариуцлага хүлээж, урьдчилан сэргийлэх ажил чанаржин хэрэг зөрчлийн тоо буурсан үзүүлэлттэй байгаа тул тайлантай танилцан дүгнэлтээ нягталж үзнэ үү. Мөн манай харъяа байгаль хамгаалагчдын тайлан ажлын мэдээлэл бүрэн хамруулж чадаагүй байсныг хүргүүлэв.

Шалгалтын танилцуулгад дурьдсан БХНСАХ-ний зардлын төсвийн төлөвлөлт, орлого бүрдүүлж төвлөрүүлэх, хуваарилалтай холбогдсон зарим зөрчил дутагдлын талаарх зөвлөмжүүдийг хариуцсан чиг үүргийнх нь дагуу холбогдох байгууллагуудад нь нэр заан тоон дүнгийн хамт зөвлөмждөө тусгаж өгөх, мөн сумдын түвшинд гарсан зөрчил дутагдлуудыг ялган холбогдох этгээдэд нь зөвлөмж, албан шаардлага хүргүүлж өгнө үү

2. Нийцлийн аудитын газарт хүргүүлэх саналд нэмж тусгуулах талаар:

2.1 Ан агнуурын нөөц ашигласны орлогыг хувьд тухайн сумын орлогод хамаартай орлого бөгөөд "Амьтаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1-д заасны дагуу БОНХАЖА-нд 10 дугаар сарын 15 ны дотор хүргүүлдэг бөгөөд яам уг саналыг нягтлан үзэж агнуурын амьтаны тоо толгойн хэмжээг "Амьтаны тухай хууль"-н 26.3-д дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын хурлаар оруулж батлуулсны дараа БОАЖСайдын тушаалаар аймагуудад хувиарлан төсөв батлагдсаны дараа ирүүлдэг, зарим тохиолдолд агнуурын амьтаны тоо толгойг өөрчлөх буюу хасдаг тул урьдчилан орлого төлөвлөхөд хүндрэлтэй байдаг ба төсвийн тухай хуулийн цагалбараас зөрүүтэй явагддаг процесс болно. / Шалгалтад хамрагдсан 2015 онд

гарсан амьтан агнах барцтай холбоотой сайдын тушаалууд, тус газрын албан бичгүүдийг хавсаргав.

2.2 Байгаль хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д заасны дагуу байгаль орчинд хохирол учруулсны нөхөн төлбөрийн орлогыг байгаль хамгаалах санд төвлөрүүлэхээр заасан боловч байгаль хамгаалах сан нь Сангийн сайдын шийдвэрээр өөрчлөгдөн БХНСАХ-ний зардал болж өөрчлөгдсөн тул цаашид уг зардлыг хаана хэрхэн төвлөрүүлж зарцуулах талаар зөвлөж, нийцлийн аудитын газарт хүргэх саналд дээрх 2 асуудлыг шийдвэрүүлэх талаар саналд нэмж оруулж өгнө үү

Хавсралт 44 хуудас

ДАРГА



Д. МӨНХ-ЭРДЭНЭ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Танай байгууллагаас ирүүлсэн албан бичигтэй танилцаад дараахь тайлбарыг хийж байна.Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 дугаар тогтоолоор төсвийн тодотголд Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг 841,000.0 мянган төгрөгөөр тусган баталсан нотлох баримт ирүүлсэн тул засварлахаар шийдвэрлэв.
2. Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогоос 217,930.0 мянган төгрөг буюу 80 хувь нь зориулалт бусаар зарцуулагдсан нь нотлох баримтаар батлагдаж буй тул засварлах шаардлагагүй байна.
3. Аймгийн МХГ-аас төлөвлөгөөт шалгалт хийгдээгүй учраас тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.
4. БОАЖГ-ын хүсэлтийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.